

МАЛ АЖ АХУЙ ДАХЬ ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛД БИЕ ДААСАН БАЙДАЛ ХОЛБОГДОХ НЬ

Б. Наранбаатар

Докторант

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

0000-0003-1402-9210

DOI: 10.66753/

philosophy@must.edu.mn

Б. Батсүрэн

Докторант

Барилга, архитектурын сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

0009-0005-1665-9197

DOI: 10.66753/

batsuren@must.edu.mn

Хураангуй: Гэр бүлийн гишүүдийн харилцаанд оролцооны эрх нь өмчийн эрх мэдэл, хуваарилалтад гэр бүлийн гишүүдийн харилцааны хэм хэмжээнд хэрхэн тусгагдсан талаархи онолын үндэслэлийг гаргав. Эрх мэдэл, харилцан итгэлцэл, халамж, сайн дурын эрх мэдлийн байр суурийн харилцан орлох байдал, багтан орж буй өрх бүлийн дээд эрэмбийн зорилгоос үүдэлтэй үүргийн өөрчлөлт нь эхчүүд, хүүхдийн эрхийн өргөжүүлэлт нь хяналтыг бууруулсан байдлаар гэр бүлийн хэв маягуудын ангиллыг гарган монголчуудын өрх бүлийн хэв маягууд (өрх бүл, хот айл, саахалт айл, отог хүрээ)-тай харьцуулан судлав.

МАА-н хүрээнд өрхийн гишүүдийн хооронд үүсэж байгаа өмчийн эрхийн асуудалд түүхэн ба системийн хандлагаар авч үзэв. Малыг амжиргааны хэрэгсэл гэх нь байгальтайгаа хандсан уламжлалт экологийн хэм хэмжээт ёс зүйн харилцаатай зөрчилдөж байна. Мал сүргийн өсөлт, сүргийн бүтцийн өөрчлөлт нь эхчүүд, хүүхдийн хөдөлмөрт зарим хүндрэл үзүүлж байна. Чадавхижуулах, санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, өмчийн хуваарилалтад оролцоог нэмэгдүүлэх зэрэгт түүхий эд бэлтгэлийн өрх бүлд суурилсан өнөөгийн бүтэц нь энэ бүлгийн өмчийн хуваарилалтын оролцооны эрхийг хязгаарлаж байна. Малын ноос ноолуур бэлтгэх, эх малын тэжээл, төл малыг тэжээн тэнхрүүлэхэд эхчүүд, хүүхдийн хөдөлмөрийн онцлог харагддаг. Хүүхдийн суралцах эрхийг хангах, асран хамгаалах үүргийн хүрээнд эхчүүд суурин газар бараадаг ч ажлын байр хомс байдаг. Цаашилаад эрчүүд бэлчээрээ даган алсын отор нүүдэл хийхэд ямаан сүргийн нас гүйцсэн, эр мал сүргийн бүтцэд зонхилж эргээд ноолуурын чанар үйлдвэрлэгчийн шаардлагад нийцэхгүй байдалд хүргэж байна. Нэгдэлжих хөдөлгөөний үед Нэгдлийн гишүүнээр 16 настнуудыг бүртгэлжүүлсэн туршилагад тулгуурлан хүүхдийн хөдөлмөрийг албажуулан бүртгэж, хөдөлмөрийн үнэлгээнд оруулах шаардлагатай байгаа юм. Тиймээс төв суурингийн дэд бүтцийг түшиглэн ноос, ноолуур самнах, угаах үйлдвэрлэл хөгжүүлэх нь түүхий эд бэлтгэлийн өртгийг бууруулж чанарыг дээшлүүлэх, нөгөө талаас эхчүүд, хүүхдүүд хөдөлмөрөө үнэлүүлэн өмчийн хуваарилалтад оролцох эрхийг өргөжүүлэх боломжийн хувилбарыг өрх бүлийн уламжлалт хэв маягуудыг гарган тавьсанаар санал болгож

байна. Эдгээр хэв маягууд оюутнуудын Аз жаргал эссе бичвэрийн агуулгад чанарын судалгаа хийснээр зохих хэмжээгээр хадгалагдан үлдсэн нь сонирхол татаж байна.

Түлхүүр үг: Гэр бүлийн сайн сайхан байдал, бие даасан байдал, тэгш хэмт харилцаа, хяналт, харилцааны хэм хэмжээ, эрхийн өргөжүүлэлт, оролцооны тэгш эрх

УДИРТГАЛ

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэн нийлүүлэх үе шатанд аж ахуйн үндсэн зохион байгуулалтын хэв маяг нь өрх бүл, түүнд суурилсан хот айл, саахалт айл, хүрээний зохион байгуулалт юм. Тиймээс нийт системийн судалгаа нь өрх бүлийн гишүүдийн хөдөлмөр зохион байгуулалт, үр ашгийн хуваарилалт, өмчийн эзэмшилд эзлэх байр суурь, дээд эрэмбийн системд гүйцэтгэж буй үүрэг, өмчийн эрх, өмчийн хуваарилалтийн эрх мэдлийн асуудал нь нийт үйлдвэрлэлийн ерөнхий төрх төлөвт онцгой нөлөөтэй. Нийгмийн сайн сайхан байдал нь хувийн эрх ашгийг дээдлэх либертари онол, олонхийн эрх ашгийг дээдлэх утилитари онол, нийгмийн эрхэм дээд эрх ашгийг хамгаалах эвдемонист онолын хүрээнд яригддаг. Эхнийх нь хувь хүний мэдрэмж таашаал, түүнийг хангах нийгмийн нөхцлийг бүрдүүлсэн таатай орчныг авч үздэг бол удаах нь хувийн амжилт нь тэгш боломжийн зохистой хуваарилалтад хувь нэмрээ оруулсан эсэхээр үнэлэгддэг. Гурав дахь нь эхний 2 онолын хэрэгжин биелсэн нөхцөлд л нийгмийн зорилго, эрхэмлэл хангагдана гэдэг. Аль алинд нь нийгмийн тэгш эрх, эрх чөлөө, боломжийн тэгш хүртээмж хөндөгддөг.

Систем дээд эрэмийн системд багтан орсон хир хэмжээгээр орчны өөрчлөлтөд тогтвортой үйлдэн оршдог. Тогтсон системийн хүрээнд үнэлэмж системдээ гүйцэтгэж байгаа үүрэг, үнэлэмжийн баримжаа нь дээд эрэмбийн системийн хүрээнд өөрчлөгддөг төдийгүй эсрэг чиг үүрэгт байраа тавьж өгөх нь бий. Системийн харилцааг хадгалж барьж тогтоох чигийн чиг үүрэг нь эсрэгээр халж солих, задлан бутаргах чиг үүргээр ч солигдож болно. [1] Бие даасан байдал нь нэгэнтээ өөрийн багтан орж байгаа бүлгийн хүрээнд хувийн эрх ашгийг хамгаалах, төрөлхийн мэдрэмж таашаалыг эрхэмлэх субьектив байдлаар илэрнэ. Анхдагч бүлэг буюу гэр бүл, үе тэнгийн бүлгээс дээд боловсролын буюу институтын хүрээнд хамт олны сайн сайхан байдлыг хангах зорилгын хүрээнд бие даасан байдлаа хангах нь харилцааны уламжлалт бүтцийг өөрчлөхөд хүргэж байгаа нь оюутнуудын гэр бүлдээ гүйцэтгэж байгаа үүрэг, эрхийн харилцаанд ч тусгалаа олдог. Нэгдэлжих хөдөлгөөний амжилт нь хөдөлмөрийн нөөцийг нэмэгдүүлэхээс хамаарсан. “Хөдөлмөрийн хуулийн дагуу ХААН-үүд 1960 оноос 16 нас болон түүнээс дээш насны хүмүүсийг нэгдлийн гишүүнээр элсүүлэхээр журамласан байна”. [2] МАА-н үйлдвэрлэлийн онцлогоос үүдэлтэй өмчийн харилцаанд бие даасан байдал, оролцооны тэгш байдалд төрөөс ийн анхаарч ирсэн байдаг.

Хүний эрх, эрх чөлөө, боломжийн тэгш байдлын үүднээс аль ч түвшний нийгмийн бүлэг, нийтлэгийн чиг үүрэг болон боловсролын зорилго, нийгмийн зорилгын хамаарлын судалгаа хийгдэж байна. “Улс орны, нөгөөтэйгүүр нийгмийн дүр төрхийг иргэнийх нь аз жаргал, хэрхэн нийгэмдээ аж төрж буй дүр төрхтэй холбож үзвэл зохимжтой. Үүний тулд иргэнлэг шинжийг шинжлэх хэрэгтэй. Иргэнлэг шинж чанарыг төлөвшүүлэх (citizenship building) гол талбар бол боловсрол юм. Вайл Войжелерс (Weil Veugelers) Нидерланд улсын иргэдээс иргэний ямар шинж чанар чухал болох талаархи эцэг эх, багш, сурагчдыг хамруулан судлахад дараахь 3 шинжийг онцолсон. Үүнд:

- Сахилга бат (discipline): дуулгавартай, сайн зан төлөв, өөрийн сахилга,
- Бие даасан байх (autonomy): өөрийн гэсэн бодолтой байх, шүүмжлэлийг зохицуулж сурах,
- Нийгмийн төлөө санаа тавих (social concern): өрөвдөх сэтгэл, өөр үзэл бодолтой хүмүүсийг хүндэтгэх, бусадтай эв нэгдэлтэй байх зэрэг шинжүүд багтана.” [3] Хяналтын гүйцэтгэх үүргийг харилцан итгэлцэлийн өндөр түвшин орлох боломжтой гэсэн үг. Энэхүү илтгэлд философийн хичээл судалж байгаа 1-р курсын оюутнуудын “Аз жаргал” эссе бичвэрийн агуулгад чанарын судалгаа хийн МАА-н өрхийн үйлдвэрлэл дэх өрхийн гишүүдийн харилцааны хүрээнд бие даасан байдал болон үйлдвэрлэлийн гинжин хэлхээн дэх дээд эрэмбийн зорилтуудтай хэрхэн уялдаж байгааг боловсролын хүмүүнлэгийн парадигмын хүрээнд багтах сэтгэл судлал, философийн онолуудаар тайлбарлахыг зорив.

Гэр бүлийн сайн сайхан, бие даасан байдлын харилцааны асуудал

Энэ хүрээнд шинэ Z үеийнхэний онцлогийн хүрээнд боловсролын харилцаанд оролцогсдын баримтлах ёс суртахууны үндсэн зарчим, ёс суртахууны хэм хэмжээ, үүрэг, хариуцлага, үнэлэмжийн судалгаа яригдана. “Z” үеийн тухай судлаачдын дүгнэлт сонирхол татдаг. Бие даасан байдлыг маш их эрхэмлэнэ. Иймээс заах, сургамжлах уламжлалт арга барилд төдийлөн дуртай биш. Тиймээс боловсролыг онлайн, офлайн, аль болох дөт замаар олж авахыг хүсдэг, тийм ч боломжтой. Тэднийг эцэг эх, эмээ өвөө, ах эгчийн халуун хайр халамжийг хамгийн их мэдэрсэн үеийнхэн гэж тодотгожээ. [4] Оюутнуудын эссе бичвэрийн агуулгад гэр бүлийн сайн сайн байдал болон хувийн мэдрэмж таашаалыг хангахад технологийн үр нөлөөний талаар нилээдгүй дурьдагдсан.


1. Бие даасан байдал ба оролцоонд суурилсан эрхийн өргөжүүлэлт

Гэр бүлийн гишүүдийн харилцааны хэм хэмжээ, талуудын үүрэг, багтан орж буй нийтлэгийн сайн сайхан байдлын талаархи судалгаа Эртний

грекээс эхтэй. Никомахын ёс зүй зохиолд Аристотель алтан дунджийн онолын үүднээс хандсан. Тэгш хэмт харилцаа нь нөхөрлөлийн сайн шинж бөгөөд ашиг, таашаалд тулгуурласан нөхөрлөл нь тэгш хэмт бус харилцаанд хүргэнэ. Аристотелийн үзлээр, “ашиг хонжоо бодсон нөхөрлөл гомдол зэмлэлийг тээж байдаг ажээ. Нэг нь нөгөөгөөсөө дэмжлэг хүсдэг. Тэгэхдээ ямагт илүү ихийг хүсдэг. Үзүүлсэн дэмжлэгийг ямагт бага байна хэмээн дургүйцдэг. Энэ бол жинхэнэ нөхөрлөл биш.” [5, р. 86]. Өгсөн нь хариу барьдаг “Өгөө-авааны харилцаа”-наас гадна сайн дурын, өгөөмөр, харилцан буулт хийдэг тэгш эрхийн харилцааг гэр бүлийн сайн сайхан байдлын үндэс гэжээ. Итгэлцэлийн харилцаа нь хяналт, үл итгэх байдлыг бууруулж хүүхдэд бие даасан байдал буюу санхүү, шийдвэр гаргах, сонголт хийх зэрэг эрхийг нь нэмэгдүүлж байх замаар эцэг эхчүүд өөрсдийн ачааллыг бууруулах ухаалаг шийдвэр юм. Итгэлцэл – бие даасан байдал – дээд сайн сайхан байдал. “Никомахын ёс зүй зохиолд хүнийг хэрхэн хүмүүжүүлэх вэ? Гэдэг асуултад: Хүмүүсийн олонхи нь шүүн тунгаахаас илүү албадлага, дарамт шахалтад дуртай, түүнд дуулгавартай байдгийг бичсэн байдаг. Албадлагын зүйл бол хүмүүсийн хүчинд автаж л хийдэг зүйл. “Хүчирхийлсэн аливаа хэрэг ямагт адгийн байдаг”.⁴ Хүмүүс бодох эргэцүүлэх, юу нь сайн, сайхан бэ? Гэдгийг шүүн тунгааж олохоос илүү бусдын зааварчилгаагаар байх нь хялбар байдаг. [5] Энэхүү хялбар байдал нь эргээд хувийн аз жаргалыг төдийгүй эрхэм дээд сайн сайн буюу гэр бүлийн аз жаргалыг бүтээхэд саад болдог гэсэн дүгнэлт хийж болно.

Бие даасан байдал нь уламжлалт харилцаанд шинээр харгалзах шаардлага бүхий тал орж ирдэг. Хяналтын үүргийг хумьж өөрийн мэдрэмж таашаалыг харгалзах шаардлагаар эрх чөлөөг нэмэгдүүлсэнээр бусдын эрхийг хязгаарлах нь хариуцлага буюу үр дагаврын бүхий л тооцоог өөртөө төдийгүй бусад хүмүүст хамаатай байдлаа тооцох боломжгүй нь уламжлалт харилцааны бүтцийн хүрээнд шинэ үүргийн функци тохирохгүй байгаатай холбоотой. Шинэ орчинд учирсан эрх чөлөөг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл нь хяналтын үүргээсээ эцэг, эхчүүд өөрсдийгөө чөлөөлөх явдал юм.

1-р зураг. Бие даасан байдал, хяналт, нийтийн сайн сайхан байдлын зохицол



⁴ Аристотель. Эвдемийн ёс зүй – Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. УБ.,2011. II боть. 116 дахь тал.

Карл Рожерс “Хоёр төрлийн Би хоорондын зохицол нь цаашид хүүхдийг шинэ орчинд орж нийгмийн бусад бүлэгт байр сууриа бататгах нөхцөл болно гэсэн. Өөрийн эрхэм чанар, ялгаатай байдлаа мэдрэх тусам, өөр соёлд нэвтрэх, тэдгээр соёлын орчинд хүлээцтэй хандах, олон соёлт байдалд эрхэм чанарыг хүлээн зөвшөөрөх, алагчлалгүй хандлагад суралцах юм” [6]. Нийтлэг хэм хэмжээ тогтсоноор хүртээмжийн тэгш байдалд хүрч тэгш бус байдлыг ойртуулах нөхцөл бүрдэнэ. Идеаль би нь гэр бүлийн зүгээс үзүүлж буй хяналт болон шаардлагын цогц юм. Монголчуудын эрхлэх аж ахуйн онцлогоос үүдэлтэй өрх бүлийн олон тогтолцоо оршин байсны эрхээр гэр бүл дэх гишүүнд тавигдах үүргийн хэм хэмжээ харилцан адилгүй. Хүүхэд л гэхэд олон түвшинт шаардлагатай тулгардаг. Гэр бүлийнхээ аль ч түвшний хүрээнд тавигдаж байгаа зорилгыг ухаарч өөрийн Би-ийн эрх ашгийг уялдуулсанаар хувийн бие даасан байдал ба нийтийн сайн сайхан байдал хангагдана гэсэн үг. Аль ч түвшний системийн гадаад харилцан үйлдэл дээд эрэмбийн зорилттойгоо уялдсан нөхцөлд л бүтцийн тогтвортой байдлаа тогтоон барьдаг гэдэгт системийн онол тулгуурладаг.

Ийнхүү гэр бүлийн хэв маягаас үүдэн мал сүрэг нь өрх бүлийн аж ахуйн өөрийгөө тэтгэх, амжиргааны эх сурвалж гэдгээс давсан утгыг илэрхийлнэ. Өрх гэрийн гишүүдийн эрх хэмжээний урьдаас тогтоогдсон байдал харьцангуй. Аж ахуйн үйл ажиллагаа улирлын, хөдөлмөрийн үйл ажиллагааны зохицуулалтаас хамааран гишүүд нэгнийхээ гүйцэтгэх үүргийг орлодог. Өрхийн тэргүүн юм уу хэн нэгэн гишүүн алс хол жин тээх, төрийн бусад албанд томилогдох зэргээс үүргийг нь хэн нэгний эрхийн өргөжүүлэлт үүсдэг. Хүн бүл цөөтэй айлд хүүхэд, эхчүүд ч энэ үүргийг авч болно. ХХ зууны ХАА-н нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалтын үндсэн нэгж нь суурь байв. “Суурийг малын зүс, ашиг шим мэтээр малчдын хөдөлмөрийн хуваарийг хатуу баримтлан уламжлалт өрх айлын харилцан туслалцдаг, тодорхой шижмээр холбогдсон хот айлын тогтолцоо алдагдсанаар өрхийн эзнийг өрхийн бусад гишүүдээс нь орлох боломжгүй болгов.” [7]

Судлаачдын дунд гэр бүлийн гишүүдийн харилцааны хэв маягаас шалтгаалж 3 төрлийг ялган тодорхойлдог. Судлаач Диана Баумринд (Diana Baumrind) эцэг эхийн хяналт болон халамжийн түвшнээс хамааран authoritarian, authoritative, permissive гэсэн гурван үндсэн хэв маягийг тодорхойлсон. Нэг болон гурав дахь хэв маяг нь хяналт ба бие даасан байдлыг тус тус туйлшруулан авч үзсэн бол хоёр дахь хэв маягийн судалгааг Маккоби ба Мартин (Maccoby and Martin, 1983) нар өргөжүүлж, гэр бүлийн харилцааг хяналт (control) ба халамж (warmth)-ийн уулзварт авч үзсэн. Хяналтын түвшин бие даасан байдал буюу эрхийн хязгаарлалтыг шаарддаг. Эдгээр ойлголтоор илэрхийлэгдэж байгаа харилцаа нь гэр бүл гэсэн өрнийн соёлын хүрээнд

яригддаг тул хүүхдийн эрх чөлөө, бие даасан байдал нь гэр бүлийн сайн сайхан байдлаас тусад нь авч үздэг.

Соёл ба хувь хүний харилцааг тайлбарлахад Hazel Markus болон Shinobu Kitayama (1991) нарын “independent” болон “interdependent self”-ийн онол чухал байр суурь эзэлдэг. Энэхүү онолоор барууны нийгэмд бие даасан “би” давамгайлдаг бол уламжлалт болон хамтач соёлд харилцан хамаарал бүхий “би” илүү хөгжсөн байдаг. Нүүдлийн мал аж ахуйн соёл нь харилцан хамаарал бүхий нийгмийн хэлбэрт хамаарах тул хувь хүний шийдвэр, зан үйл нь өрх бүл⁵, ураг төрлийн хүрээнд тодорхойлогдох хандлагатай.

Ийнхүү гэр бүлээр цөм болгосон ураг төрлийн бэсрэг холбоо болох айл, нэг ба хэдэн гэр бүл, мөн өрх гэсэн бүтцийг өөртөө агуулсан айл, ураг төрлийн холбоотой, эсвэл ажил үйлдвэрлэлийн хувьд нэгдмэл гэр бүл, өрхүүдийн нэгдмэл бүтэц хот айл, хот айлын гадаад орчин хүрээ буюу хамгийн ойрын нийгэм хүмүүнлэгийн орчин нөхцөл саахалт айл гэсэн нийгмийн бүтцийн институтууд байсан. “XX зууны социалист монгол нийгэмд уламжлалт нийгмийн эдгээр бүтцүүд ихээхэн задарсан ба зарим нь устаж алга болсон байна.” [8, р. 134]

Гэр бүлийн гишүүдийн эрх мэдлийн хуваарилалт, хөрөнгийн эрх, нийтлэгийн сайн сайхан байдал ба хувийн бие даасан байдлын зохилдолгоо, хяналт ба халамжийн тухай асуудал системийн онолын хүрээнд суурилагддаг. Дээрх зохилдолгоо нт бие даасан байдал нь дээд эрэмбийн системийн хүрээнд гишүүний статусын олон талт байдлаар буюу эрхийн өргөжүүлэлт байдлаар дэд эрэмбийн системийн үүргээр хангагдана. Хувийн таашаал буюу эрх чөлөөний биелэл нь системийн сайн сайхан байдлын хангахтай харилцан уялдаатай учраас таашаал хангах (утилитарианизм) нь эрхэм зорилго (эвдемонизм) хоорондын зохицол (конгруент) юм.

Энэхүү судалгааны үр дүнд оюутнуудын аз жаргалын талаарх ойлголт нь хувь хүний бие даасан байдал, нийгмийн хүлээлт, харилцааны чанарын огтлолцолд бүрэлдэж байгааг тогтоов. Гэр бүлийн уламжлалт үүргийн бүтэц нь бие даасан байдлын өсөлттэй уялдан өөрчлөгдөж, харилцан итгэлцэл, тэгш оролцоонд суурилсан шинэ харилцааны хэлбэрт шилжиж байна. Энэхүү харилцааны тэгш хэмт шинэ хэлбэр нь Бодит би-ийн төлөөлөл болсон ялгаатай бүлгүүдийг хүлээн зөвшөөрөх, тусгаар Бодит би-ийн ертөнцийг үзэхүйд хүлээцтэй, тэвчээртэй хандах байдлаар тулгамдаж буй асуудалд тэдгээр бүлгүүдийн үүднээс хандах явдал юм. Нийгмийн сайн сайхан байдал нь гэр бүлийн гишүүдийн харилцааны хүрээнд бие даасан байдлыг хангасан тодорхой түвшинд л өнөөгийн тодорхойгүй нөхцөл байдалд янз бүрийн бодит

⁵ Энэ онолын хандлагаар өрх бүл нь өргөтгөсөн гэр бүл юм.

байдалтай уялдаатай бүлгүүдийн байр сууринаас хандах чадвартай байх зорилго бүхий хүмүүнлэг боловсролын парадигматай зохицож байна.

Мөн Бодит Би болон Идеал Би-ийн зөрчил нь сөрөг үзэгдэл бус, харин бие хүний хөгжлийн зайлшгүй үе шат бөгөөд энэхүү зөрчлийг зохистойгоор шийдвэрлэх нь хувь хүний төдийгүй нийтлэгийн сайн сайхан байдлыг хангах үндэс болж байна. Энэхүү судалгаанаас харвал оюутнуудын бие даасан байдлыг гэр бүлийнхээ сайн сайхан байдалд өөрийн зүгээс оруулах хувь нэмэр хэмээн үзэж байгаа нь уламжлалт өрх бүлийн соёлын үр нөлөө зохих хэмжээгээр хадгалагдан үлдсэн байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Өрх бүлийн уламжлалт олон бүтэц алдагдсанаас өмчийн эрхийн хуваарилалтын уян хатан тогтолцоо алдагдсан. Өрх бүлийн аж ахуйн бүтцийн явцуурал нь түүхий эд бэлтгэлийн хүрээнд л аж ахуйн зорилт тавигдсанаас үүдэн гишүүдийн оролцооны хэв маягууд цөөрсөн. Эрэгтэй хүүхэд эцгийн орыг залгамжилдаг ёс бий. Овгийн ихсийн тахилгад “өрхийн тэргүүн нь балчир хүүхэд – Тэмүүжин” оролцох үүрэгтэй байснаас харагдана. Нэгдэлжих хөдөлгөөний үед хүүхдийг нэгдлийн гишүүний бүртгэлд оруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулж тодорхой үүрэг даалгавар өгч байсан нь нийгмийн хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд онцгой үүрэгтэй байсныг гэрчилнэ. “Жишээлбэл, өрх гэсэн уламжлалт институт байхад өрхийн тэргүүлэгч гэдэг нь ураг дотроо хамгийн нэр хүндтэй, гол шийдвэр гаргагч, өрхийн дотоод амьдрал ба өв хөрөнгийг захиран зарцуулагч учраас эрэгтэй хүн байх. Хэдийгээр Өүлэн эх бэлбэсэрсэн эхнэр хүний хувьд үр хүүхдээ өсгөж Есүхэй баатрын өрх гэрийг авч явсан ч өрхийн тэргүүн гэгдэхгүй, харин Тэмүүжин бол өрх гэрээ мэдэж авч явах учиртай тул усан нүдлэж болохгүй гэж хатуу зэмлүүлсэн ба ихсийн тахилгад өрхийн тэргүүн нь балчир хүүхэд – Тэмүүжин тул нэр зааж урьж залаагүй байдаг.

Ажил үүргийн соёлоос шалтгаалж эрх хэмжээг нь нэмэгдүүлдэг онцлогтой. Идеал би буюу дээд эрэмбийн шаардлага, хүлээлт ба бодит би нь харилцан зөрчилдөхгүй байдаг онцлогтой. Учир нь өрхийн тэргүүн нь хот айл дотроо л гэхэд шилжмэл байдалтай. Ихэнхдээ настай, туршлагатай хүн байдаг ч хүүхдийг өрхийн тэргүүнээр өргөмжлөх уламжлал бий. Өрх гэдэгт хэд хэдэн айлууд ч байдаг (Дашпүрэв. Д. , 2022) Ийнхүү гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааны эрх үүргийн байдал нь анхнаасаа өгөгдсөн бус харин функциональ байгаа юм. Овог, отгийн тэргүүнд эцгээ залгамжлан Тэмүүжин заларсан түүхэн баримт бий.

2. Олон хэмжээст гэр бүлийн гишүүний үүрэг ба бие даасан байдлын зөрчил

Энэхүү зөрчлийн шалтгаан нь гэр бүлийн онцлог бүхий нийгэм соёлын нөлөөнөөс гарч бие даасан байдалтай оюутны нийгмийн хүрээлэлд орох үед

үүсэх бүлгийн хүлээлт болон өөрийгөө харгалзах хоорондын зөрчлөөс үүдэлтэй. Гэр бүлд хүүхэд ийм л байх ёстой гэсэн идеаль би үүсдэг ба энэ нь талуудын харилцааны бүтцийг үүсгэдэг байна. Идеаль би нь эцэг эхийн зүгээс хүүхдээ ийм л байх ёстой гэсэн хяналттай, нэг талт харилцаа. Ийнхүү нөхөрлөлийн харилцаа нь харилцан итгэлцэлийг дээшлүүлэх, эрх чөлөөгөө ухамсартайгаар хязгаарлах(оюутан өөртөө сахилга баттай байх шаардлага тавьдаг) зэргээр цаашдын амьдралд шаардлагатай эрхийг өргөжүүлэх байдлаар илэрнэ. “Гэр бүлийн амьдрал нь найз найзтайгаа хэрхэн амьдрах вэ? Гэдэг асуултад хариулахтай адил байх юм. Гагцхүү давуутай нь давуу байдалд тэнцсэн ачлалыг найздаа үзүүлж болно гэдгийг тэрээр илэрхийлжээ. Ийм тохиолдолд л эхнэр ба нөхөр гэр бүлийн аз жаргалыг хамтдаа бүтээж байдаг. [5] Хүүхдийн хувьд ч үргэлж эцэг эх, асран хамгаалагчаасаа асран тэтгүүлж байдаг нэг талын давуутай байдлыг өөрчлөх тэр үед л жинхэнэ нөхөрлөл тогтоно хэмээн үзэж болно.

Оюутнуудын сургалтын эхний жил бол нийгмийн шинэ орчин нөхцөл, хүмүүсийн хүрээлэлд орж харилцаа хандлагын өөрчлөлтийг дагуулдаг үе билээ. Өөрийгөө зохицуулж, тохируулдаг ухаалаг системийн хувьд элементүүд багтан орж буй системдээ өөрийн шинжээс давсан харилцааны тогтсон тогтвортой харилцаанд багтан орсон бөгөөд системийн шинж нь уг элементүүдийн шинжүүдийн механик нийлбэр төдий бус. Бие хүний төлөвшлийн үндсэн үе шатны зөрчлийг хэрхэн шийдвэрлэснээр тогтсон харилцаа хандлага нь бие даасан байдалд хүргэх эргэлтийн цэг юм. Оюутнуудын эссе бичвэрт, “Ариун зүйл болон ариун бусын, хувийн эрх ашиг ба эцэг эхийн хүлээлтийн, өөрийн таашаал болон гэр бүлийн эрхэмлэлийн зөрчил” зэрэг агуулга нь энэхүү шилжилтийн үеийг харуулж байна.

Эрхийг өргөжүүлэх боломж өрх гэрийн гүйцэтгэх үүрэг буюу дээд эрэмбийн байдлаас хамаардаг. Тиймээс энд хяналт буюу шаардлага, хүлээлт нь зөвхөн өрх гэрээр хязгаарлагдахгүй. Энэ тохиолдолд хувийн эрх ашиг таашаал нь нийтийн буюу дээд эрэмбийн эрх ашигтай хэрхэн нийцэж зохилдож байгаагаас хамаарна. Оюутнууд өөрийн эрх ашиг болох бие даасан байдал нь эвдемонист шинжтэй буюу өрх гэрийн олон хэмжээст, дээд эрэмбийн шинжтэй өрх бүл, ураг төрөл, хот айл, нутаг усны гэсэн нийтлэг эрх ашгийг бодолцсон байгаа нь өрх бүлийн уламжлалт соёлын хэм хэмжээ тодорхой хэмжээгээр хадгалдагдан үлдсэнийг харуулж байна. Өрх бүлийн гишүүдийн эрхийн өргөжилт нь түүний янз бүрийн хэлбэрүүдийн дээд эрэмбийн системд гүйцэтгэж байгаа үүргээр тодорхойлогдоно. “XX зууны социалист монгол нийгмээс өмнөх үед гэр бүлийн тоог өрхийн бүртгэлд чухалчлахгүй, харин өрхийг заавал бүртгэнэ. Энэ нь төрийн албаны татвар, цэрэг болон агт морь гаргах ажилд чухал эх сурвалж болдог. [11]” Ийнхүү аль

ч түвшний нийлмэл системд багтан орж буй дэд системийг бүрдүүлэгч элемент бүтцээ бэхжүүлэх байдлаар урьдчилан тогтоогдсоноор гаднын нөлөөлөлд тэсч үлдэх чадвар (resilience)-ыг нэмэгдүүлдэг.

Монголын нүүдлийн мал аж ахуйг зөвхөн амьжиргааны хэрэгцээг хангах утилитар стратегийн тайлбар “малчин–мал сүрэг”-ийн харилцаанд шингэсэн нийгэм-соёл, экологийн болон космологийн нарийн төвөгтэй хэмжээсүүдийг бүрэн илэрхийлэхгүй. “Нүүдлийн мал аж ахуйн хүрээнд мал сүргийг зөвхөн үйлдвэрлэлийн шат дамжлага эсвэл “мөнгөжсөн эквивалент” төдийгөөр хязгаарлагдахгүй. [12] Харин мал сүрэг нь материаллаг болон сүнслэг баялгийн илэрхийлэл бөгөөд “буян хишиг” гэх ойлголтоор дамжин өрхөөс давсан харилцааны хүрээнд сайн сайхан байдал, аз хийморийг билгэддэг. Малчин хүний малаа өсгөх сонирхол нь цэвэр эдийн засгийн агуулгатай биш юм.

Энэхүү ойлголт нь эдийн засгийн явцуу хүрээнээс хальж, хэм хэмжээт-экологийн ёс зүй (normative-ecological ethics)-д суурилсан тайлбарыг шаардаж байна. Энэ хүрээнд мал аж ахуй нь богино хугацааны ашиг дээдлэхээс илүүтэйгээр хүн, амьтан, байгаль орчны хоорондын урт хугацааны тэнцвэрийг хадгалахад чиглэсэн үйл ажиллагаа болж харагдана. Мал сүргийг өсгөх, хадгалах үйл явц нь системийн сөрөн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн харилцааг бэхжүүлэх, ёс зүйн практикийг дамжуулах үүрэгтэй. Жишээлбэл, зуд зэрэг байгаль цаг уурын эрсдэлийн үед малын тоо нь шууд ашиг биш, харин эрсдэлийг даван туулах нөөц болж үйлчилдэг. Үүний зэрэгцээ мал нь бэлэглэх, зээлдүүлэх, хамтран маллах зэрэг хэлбэрээр ураг төрлийн сүлжээг бэхжүүлдэг

Мөн энэхүү судалгаа нь хүн–амьтны харилцааг нэг талт захирах бус, хамтран орших (co-domestic coexistence) шинжтэйг онцолдог. Мал маллагаа нь зөвхөн ашиг олоход бус, халамжлах, чиглүүлэх, орчинд нийцүүлэх зэрэг дадалд суурилдаг бөгөөд малчин нь амьтдын амьдралын орчил хөдөлгөөнийг зохицуулах үүрэгтэй “асран халамжлагч”-ийн хувиар оролцдог. Энэ нь өрнийн соёлын субъект–объект, хүн–амьтан гэсэн эсрэгцэлийг эвдэж, харилцан хамааралт олон оршихуйн (multispecies) систем болно. Иймд мал сүргийг зөвхөн эдийн засгийн хөрөнгө бус, харин ёс зүйн харилцааны оролцогч гэх нь зохистой

Чухал нь, энэ хандлага нь нүүдлийн аж ахуйн зорилтууд шаталсан бүтэцтэй байдгийг илэрхийлдэг. Өрхийн түвшинд хэрэгцээ хангах шийдвэр мэт харагдах үйлдлүүд нь үнэндээ илүү өргөн хүрээний дээд эрэмбийн зорилтууд—экологийн тэнцвэр, нийгмийн үргэлжлэл, космологийн зохицолд захирагддаг байна. Иймээс өрхийн хэрэгцээ хангах зэрэг дэд зорилтууд нь бие

даасан бус, харин илүү өргөн ёс зүйн тогтолцоонд багтаж, түүгээр зохицуулагддаг гэж үзэх боломжтой

Гэсэн хэдий ч нүүдлийн аж ахуйг хэт романтик байдлаар ойлгохоос зайлсхийх шаардлагатай. Судалгаанд дурдсанаар малчин–малын харилцаа нь зах зээлийн нөлөө, хөдөлмөрийн шилжилт, байгаль орчны өөрчлөлт зэргээс хамааран тасралтгүй өөрчлөгдөж байна. Ялангуяа ноолуурын үйлдвэрлэл тэлж байгаатай холбоотойгоор утилитар, зах зээлд чиглэсэн хандлага байгаа ч **хэм хэмжээт экологийн ёс зүйн** элементүүд бүрэн алдагдаагүй. Мал сүргийг өсгөх, удирдах практикийг эдийн засаг, нийгэм, экологи, ёс зүйн олон талт огтлолцолд авч үзэх хандлага нь олон оршихуйн системийн тогтвортой байдал, сөрөн тэсвэрлэх чадварыг хангахад чиглэсэн логик юм. Энэ үүднээс өөрөөс давсан үүрэг хариуцлага (moral obligation beyond self) нь хувь хүний хэрэгцээ болон системийн дээд эрэмбийн зорилтын хоорондын харилцааг тайлбарлахад оновчтой аналитик хандлага юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад өргөтгөсөн гэр бүл холбогдох нь

Уур амьсгалын өөрчлөлт нь бэлчээрийн мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтад ихээхэн нөлөөлөх болсон. Гэр бүлийн гишүүдээс бүрдсэн өрхийн аж ахуй хэмээх хязгаарлагдмал бүтэц л үлдэж хоцорчээ. Нэгэнт дээд эрэмбийн бүтэцэд хамааралтай харилцан туслах, тэжээн тэнхрүүлэх, зэрэгцэн орших соёлын үнэт зүйлийн үнэлэмж доройтсон тул гэр бүлийн гишүүдийн эрх хязгаарлагдмал, байгаль-нийгмийн тэнцвэрийг хангах үүрэг алдагдсан зэргээр үүдэлтэй мал сүргийн уламжлалт ойлголт өөрчлөгдөв. Ноолуурын үнээс шалтгаалж ямааны тоо толгой өсөж байгаа нь эдийн засгийн ашиг орлогыг нэмэгдүүлсэн талтай ч үйлдвэрлэлийн үр ашгийг дагалдуулаагүй. Анхан шатны боловсруулалт хийх нь өрх бүл дэх эхчүүд, хүүхэд, хөгшдийн хөдөлмөрөөс ихээхэн шалтгаалдаг. Өрхийн тэргүүн нь малаа оторлон адгуулж маллахаар болдог бол сургуулиа бараадан эхнэр нь хүүхдийнхээ дэргэд суурин газар амьдарч ажиллах шаардлагатай болдог нь сүргийн бүтэцэд нөлөөлж байна. Эрчүүд отор нүүдлийн ая даах болон ноолуурын гарц арвин байх талаас нь нас гүйцсэн эр ямаа маллахыг эрхэмд үздэг. Гэвч үйлдвэрлэлийн үр ашигтай байх шаардлага талаас үзвэл залуу, эм ямааг илүү өсгөх нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ. Хаягдал багатай байдлаар ноолуур самнах, эх малыг тэжээн тэнхрүүлж ноолуурын чанарыг хэвийн хэмжээнд барьж байхад эхчүүд, хүүхдийн хөдөлмөрийг дутуу үнэлж болохгүй.

Уур амьсгалын өөрчлөлттэй уялдан эмэгтэй болон хүүхдийн хөдөлмөрийн ачаалал нэмэгдэж байна. Байгалийн гамшгаас үүдэн төл мал

хорогдох, эх малын сүү татрах нь эхчүүдийн сэтгэлзүйд маш хүндээр тусдаг. Үүнийг хохирол багатай даван туулахад эх малыг тэнхрүүлэхэд шаардлагатай нэмэлт тэжээл хэр хангалттай бэлдсэнээс хамаарна. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан эхчүүд өрхийн аж ахуйн хүрээнд ажлын ачаалал нэмэгдэж байгаа ч үнэлгээ нь бага, өмчийн харилцаанд ч мөн эрх мэдэл бага байгаа нь шаардлагатай нэмэлт тэжээл бэлтгэхэд ч сөргөөр нөлөөлж байна. [9] Өрхийн тэргүүн нь мал сүргийн хүрээнд зарж борлуулах, мах бэлтгэл бэлчээр сонгох, орон нутгийн нийтийн шинжтэй шийдвэрт оролцдог зэргээс өмчийн хуваарилалтын эрх мэдлээ баталгаажуулдаг. Иймээс эхчүүдийг чадавхижуулах, олон талт орлогын эх үүсвэр, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэн өмчийн эрхийг өргөжүүлэх шаардлагатай [9]. Судлаач С.Түмэндэлгэр цааш нь өрхийн аж ахуйд мал мах бэлтгэл, малын арилжаа солилцоо, отор нүүдэл эрэгтэйн эрх мэдэлд хамаарах тул өмчийн эзэмшил ч шилждэг. Эхчүүд, хүүхдүүдийн хөдөлмөр эдийн засгийн үнэлгээнд төдийлөн өртдөггүй гэж үзсэн нь өрхийн аж ахуйн хязгаарлагдмал талыг харуулж байна.

Алс холын отор нүүдэл хийж малд тарга тэвээрэг авахуулахаас илүү хахир хүйтэн өвлийг даах чадалтай нас гүйцсэн эр ямааг маллах сонирхолтой болжээ. Ийнхүү худаг ус, дэд бүтцээ бараадсан мал ахуй бэлчээрт ихээхэн дарамт болж газрын доройтлыг үүсгээд байгаа юм. Ямаан сүрэгт бага насны, эм малын эзлэх хувийн жин багассанаар ноолуур бүдүүрэх, үйлдвэрлэгчийн шаардлагад нийцэхгүй байх талтай. Нас гүйцсэн эр ямаа зонхилох нь алсын отор нүүдлийн ая дааж онд орох тэсвэр илүү учраас малчнаас арчилгаа маллагаа харьцангуй бага шаарддаг.

Өрх гэрийн уламжлалт зохион байгуулалтын хэв маягууд сэргэх болон шинэлэг зохион байгуулалтыг бүтцүүд үүссэнээр гишүүдийн үүргийг тодорхойлж энэ үндсэн дээр эрхийг өргөжүүлэх (санхүүгийн эрх мэдэл, гэр бүлийн доторхи өмчийн эрх, өрхийн хөрөнгийн зарцуулалт)-ыг дагалдуулна.

Ийнхүү өрх бүлийн явцуу зорилго буюу малаа ашиг олохоор ноолуурын чиглэлээр экстенсив өсгөх нь бэлчээрийн доройтол болон дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй уялдан дараахь хүндрэл үүсгэж байна. Өрх бүл дэх өмчийн эрх өрхийн эзэнд хамаарагдаж хянах, захиран зарцуулах хууль зүйн чадамж тэгш бус хуваарилагддаг. Өрхийн эзний хөдөлмөрийн хуваарьтай холбоотой отор нүүдэл хийх, эхчүүд хүүхдүүд төвөө бараадан МАА-н ажлаас хөндийрөх хандлага нь отор нүүдлийн ая даах байгалийн зохилдолгоогоор нас гүйцсэн эр ямаа зонхилдог. Энэ нь ноолуурын чанарт сөргөөр нөлөөлж түүхий эд худалдан авч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хэрэгцээг хангадаггүй. Угтаа залуу, эм ямааны ноолуур шаардлагатай. Энэ төрлийн хөдөлмөрийн хуваарь нь эхчүүд, хүүхдүүдэд хамаатай. Манай нөхцөлд хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахаар төв суурин бараадсан эхчүүдэд ноолуур самнах,

угаах ажлын байрыг бий болгон үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчийн завсрын үе шатны анхан шатны боловсруулалтыг хангаснаар энэ зорилт биелнэ.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Ямар ч төрлийн нарийн төвөгтэй систем нь өөрийн багтан орж буй дээд системийн нэгэн хэсэг болсоноор гаднын нөлөөлөлд бүтцийн тогтвортой байдлаа хадгалж уг системийн бүрдэл элементүүд дотоод чиг үүрээ биелүүлэх боломжтой болдог байна. Энэхүү гадаад чиг үүрэг нь байгалийн системийн тогтвортой байдлыг хадгалах экоцентризмын үзэл хандлага юм. Тиймээс өрх бүлийн аж ахуйн уламжлалт хэв маягууд сэргэх болон шинээр ч үүсэх магадлалтай. Ялангуяа дэлхийн томоохон нэр хүндтэй брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн шаардлага нүүдлийн МАА-н **норматив-экологийн ёс** зүйн хэм хэмжээг баримжаалж байна.

Бие даасан байдал нэмэгдэх тусам анхдагч бүлэг болох гэр бүлийн гишүүдийн тогтсон харилцааны бүтэц өөрчлөгдөн гишүүдэд нийгэм соёлын хүчин зүйлийн нөлөөг бие даасан байдал голлох хүчин зүйл болсоноор нийтлэгийн сайн сайхан байдлын буюу багтан орж буй бүлэг, нийтлэгийнхээ зорилготой өөрийн үйл ажиллагааг уялдуулах чадварыг олгоно гэж үзлээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Эссе бичлэгийн агуулгыг үзвэл оюутнууд зөрчлийг шийдвэрлэх чиг баримжааг тогтоож байна. Оюутнууд эхний хичээлийн жилд мэргэжил сонголтоо хийсэн болохоор ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж байна. Тиймээс утилитари хандлага давамгайлж байна. Ирээдүйд мэргэжил нь нийгмийн эрэлт хэрэгцээг хангаж ихээхэн орлоготой хангалуун амьдрах утилитари төсөөлөлтэй. Харин эвдемонист болон деонтологи хандлага дагалдан гарч ирж байна.

1. Үүргийн тогтсон харилцаа нь уламжлалт гэр бүлийн харилцааны бүтцийг тогтвортой хадгалж эрх, үүрэг, хариуцлага яригдана. Судалгаанд оролцогсдын 70 хувь нь гэр бүлийн орчин нь аз жаргалтай холбоотой хандлагаа илэрхийлсэн.

2. Эвдемонизм. Хувийн бие даасан байдал буюу өөрийн мэдрэмж, таашаалыг харгалзах нь бусдаар хүлээн зөвшөөрүүлэх болон хувийн эрх чөлөө нь бусдын сонголтын боломжийг өргөжүүлж байгаа ⁶ хир хэмжээгээр баталгаажина. Дээрх хариултыг сонгосон оюутнуудын эссений агуулгад хувьч чанартай холбоотой бие даасан байдал, таашаал мэдрэмж нь нийтэд тустай байдал, нийтийн үйл хэрэгтэй уялдуулан аз жаргалыг тодорхойлж байна. Энд

⁶ Гэр бүлийн орчинд ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөнөөр үе тэнгийнхэний дунд ялгаатай хэрэгцээ, хандлагийн орших зохистой орчин бүрдэн нөхцөл бүрдэнэ хэмээн үзэхэд хүргэдэг.

л нийгмийн сайн сайхан байдлыг таашаалын мэдрэмж, хувийн мэдрэмж хоорондын зүй зохистой байдлын уялдааг олж харж болно.

Гэр бүлийн гишүүдийн хүрээнд эрх тэгш байдалд хүрч хамтач байдал, харилцан буулт хийх, итгэлцэл тогтох зэргийг үүргийн хуваарилалтыг дахин зохион байгуулахад хүргэх талаар бас дурьдагдаж байна.

Тулгамдаж буй сорилтоос санал болгох бодлогын хувилбар

1. Хүүхдийн үүрэг:

- Сүргийн бүтцэд үзүүлэх нөлөө: Хүүхдүүд төл мал хариулах, эхэд нь амлуулах, төл тавих зэрэг "арчилгаа" шаардсан, чимхлүүр ажил ногддог. Энэ нь төл малын хорогдлыг бууруулж, сүргийн бүтцэд "залуу малын" сэлгээг нэмэгдүүлдэг.
- Түүхий эдийн чанар: Төл малын ноос, арьс ширийг хаягдалгүй боловсруулах анхан шатны мэдлэгийг соёлын залгамж чанарыг хангадаг.

2. Эхчүүдийн үүрэг

Эхчүүдийн хөдөлмөр голчлон мал саах, сүү цагаан идээ боловсруулах, малын хашаа саравчны эрүүл ахуйд холбогдоно.

- Сүргийн бүтцэд үзүүлэх нөлөө: Эхчүүдийн хөдөлмөрийн ачаалал, саах техникийн чадавхаас хамаарч тухайн өрх сүргийн бүтцэдээ "саамны мал" (үнээ, эм хонь, ямаа) хэдэн хувь байлгахыг шийддэг. Хэрэв эмэгтэй хүний хөдөлмөрийн нөөц бага бол саалийн малын тоог цөөрүүлж, "махны" эсвэл "эр хонь, ямаа" бүхий сүргийн бүтэц рүү хэлбийдэг.
- Хаягдалгүй боловсруулалт: Сүүний дагалдах бүтээгдэхүүн (шар сүү, өрөмний тос г.м)-ийг боловсруулах, ноос ноолуурын үс хялгасыг түүх, ангилан ялгах анхан шатны боловсруулалтыг дээшлүүлдэг.

3. Эрэгтэйчүүдийн үүрэг


Өрхийн тэргүүн нь мал сүргийн хариулга, отор нүүдэл, мал хөнгөлөх, нядалгаа, махны худалдаа болон сүргийн ерөнхий бүтцийг зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.

- Сүргийн бүтцэд үзүүлэх нөлөө: Зах зээлийн эрэлт, байгаль цаг уурын сорилтод тулгуурлан сүргийн нас, хүйсийн харьцааг (жишээ нь, хэдэн эр хонь бордож зарах, хэчнээн охин төл үлдээх) тодорхойлдог. "Эр малын" арчилгаа, алсын отор нь малын жин, чанарт нөлөөлж, сүргийн эдийн засгийн үнэлэмжийг өсгөдөг.
- Түүхий эд бэлтгэл: Мал нядлах үед арьс ширийг гэмтээлгүй өвчих, ноос хяргах зэрэг үндсэн түүхий эдийн "биет" боловсруулалтыг хариуцдаг.

Энэ бүхнээс эхчүүд, хүүхдийн хөдөлмөрийн ачааллыг хөнгөвчлөх нь малын тэжээл тариалах, төл малыг тусгайлан хашаалах, хаягдал болж байгаа түүхий эд боловсруулах хавсарга үйлдвэрлэл эрхэлж өрхийн орлогыг

нэмэгдүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогын зөвлөмжүүд бий. Ноос, ноолуур хавар 5-9 сард хяргаад 10-аас дараагийн 1 сар хүртэл самнах үе шатууд байна. Эхчүүд хүүхдээ бараадан төв суурин бараадах нийтлэг үзэгдлийг харгалзан ноос, ноолуур самнах үйлдвэрлэлийн ажлын байраар өрхийн эдгээр гишүүдийг хангавал хөдөлмөрийн нөөц бүрэн ашиглагдах төдийгүй хүүхдийн сурч боловсрох, асран хамгаалуулах эрх хангагдах, хөдөлмөрийн харилцаанд бие даасан байдлаар оролцох боломж нэмэгдэнэ гэж бид үзэж байна. Хүүхдийн хөдөлмөрийг "дутуу үнэлэх" нь системийн ирээдүйн залгамж халаа болон түүхий эдийн хаягдалгүй боловсруулах соёлыг эрсдэлд оруулдаг. Иймд хөдөлмөрийн энэхүү уламжлалт хуваарилалтыг "хамжилцах соёл"-оор баяжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг баталгаажуулах зэргээр шаардлагатай эрхийг нь өргөжүүлэх нь олон хэмжээст өрх бүлийн тогтвортой байдлын баталгаа болох боломжтой гэж бид үзэж байна.

2-р зураг. Малчдын хоршоо, Олон улсын байгууллага насаар ангилж бэлтгэсэн ноолуурын судалгаа



Малчдын хоршоо болон ОУ-ын байгууллагууд ямааны ноолуур нас гүйцэхээр бүдүүрч байгааг мэдэж аль болох бага насны эм ямааны ноолуурыг тусгайлан бэлтгэж, түүгээр хагас болон эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд өндөр үнээр нийлүүлэх боломжийг судлан ажиллаж байна [13].

Самнах шатны үйлдвэрлэл нь УБ хотод байдаг учир тээвэрлэлтийн зардал нь өртгийн 50 орчим хувийг эзэлж байна. Иймээс орон нутагтаа л анхан шатны боловсруулалт хийхээс аргагүй. Үргэжлүүлээд 12-04 саруудад угаах шатны ажиллах хүч сул зогсдог тул самнах шат дамжлагын үйлдвэрлэл рүү шилжүүлэн ажиллуулж болно.

Нүүдлийн МАА-д нэгдэл, хоршоолол, малчдын бүлэг гэх мэт хамтын хөдөлмөрийн зохион байгуулалт үйлдэрлэлийн угаах самнах анхан шатны боловсруулалтын хүрээнд хүнийн нөөцийг хуваарилан ажиллуулах

боломжтой. Хамгийн нарийн ширхэгтэй, хүний эрүүл мэндэд нэн тохиромжтой, байгаль, малдаа ээлтэй аргаар бэлтгэгддэг ноолууртай онцлогоо харгалзвал ээрэх, нэхэх зэрэг гүн боловсруулалт хийгдэн өндөр технологи бүхий итали, франц зэрэг өндөр үнэ төлөх чадвартай хэрэглэгчдийн зах зээлд нэвтрэн экспортоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

ДҮГНЭЛТ

ШУТИС-ийн оюутнуудын Аз жаргалын талаарх эссе бичвэрт анализ хийж үзвэл МАА-н өрхийн үйлдвэрэлтэй холбоотой хувийн бие даасан байдлын хэмжигдэхүүн болох хувийн эрх ашгаа харгалзахдаа өрх бүлийн, хамт олны зэрэг дээд эрэмбийн хүрээний сайн сайхан байдлыг дурьдаж байгаа нь өрх бүлийн уламжлалт харилцааны хэм хэмжээ хадгалагдсаныг харуулж байна.

Ийнхүү дээд эрэмбийн харилцаа нь хүүхэд, эхчүүдийн хөдөлмөр нь аж ахуйнхаа дотоод харилцааг батжуулан бэхжүүлэхэд туслах шинжтэй бус үндсэн үүргийг гүйцэтгэж байна. Хүүхдүүд хөдөлмөрлах явцдаа уламжлалт мэдлэг ухааныг эзэмшиж байгальтайгаа нэгдэлтэй оршдог нүүдлийн МАА-н өөрт нь зуршмал, үндсэн өгөгдлийг хадгалдаг төдийгүй байгаль орчноо хамгаалах, нэгдмэл цул чанарыг хангах үүргийг гүйцэтгэдэг.

Дэлхийн худалдаанд хүүхдийн эрхийг хангах хүрээнд байгальд уламжлалт аргаар бэлдсэн буюу хүүхдийн гар оролцсон хүчирхийлэлгүй буюу жам ёсны үйл явцад хөндлөнгөөс оролцоогүй гэсэн ногоон шошго бүхий үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэлгээний жишиг тогтож байна. өндөр байна. Хөдөлмөрлөх эрхийг өргөжүүлэх нэгэн боломж юм.

Ийнхүү боловсролоор дамжуулан нийгмийн зорилго, гэр бүлийн гишүүдийн харилцааны тэгш хэм, зэрэг онолын үзэл баримтлал МАА-н үйлдвэрлэлд оролцогсдын өрх бүлийн харилцааны хэм хэмжээг тодруулж байгаа юм. Уламжлалт болон үйлдвэрлэлийн шаардлагаар мал сүргээ өсгөх сонирхол нь Өмчийн эрх мэдэл тэгш бус хуваарилагдаж дэлхийн дулаарал нь эхчүүд, хүүхдийн хөдөлмөрийн ачааллыг бие, сэтгэлзүйн хувьд улам дарамт учруулж байгаа. Эх мал, төл малыг тэжээн тэнхрүүлэхэд тэд ихээхэн үүрэгтэй ба ялангуяа эх хүний өрөвч нинжин сэтгэл, хүүхдийн нягт нямбай хөдөлмөр угаас зуршмал юм. Байгальд ээлтэй, хатуурхаагүй, хүчирхийлээгүй аргаар бэлтгэсэн, хүний эрхийг дээдэлсэн хөдөлмөрийн оролцоотой гэсэн МАА-н түүхий эд гэсэн брэндийн хөгжүүлэлт ч байж болох юм.

НОМЗҮЙ

1. *Н. Хавх, Нийгмийн гүн ухаан., Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2000.*
2. *Алтантөгс Н. ба бусад., "Сум-нэгдлийн тогтолцоо," in Сум нэгдлийн малчдын мал аж ахуйн үйлдвэрлэл, Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК., 2023, pp. 185-240.*

3. А. Цанжид, Хувирган өөрчлөгч боловсрол: Дэлхийн чиг хандлага ба боловсролын философи, бодлогын зарим асуудал, Улаанбаатар, 2025.
4. О. Пүрэв, Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, аргазүй, Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК, 2021.
5. Эрдэнэбаяр, Г., Оюунгэрэл, Д., "Гэр бүлийн аз жаргалын үндэс сайн үйл болох тухайд," Гэр бүлийн ёс зүйн асуудал. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл, pp. 76-89, 2020.
6. Р. Карл, Оришхуйн замнал Орч., Даваажаргал, А., Улаанбаатар: Psychology publishing, 2022.
7. Наранбаатар. Б., "Монголчуудын нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн хотжилтын хандлага," ШУТИС Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, pp. 156-163, 2025.
8. Д. Дашипүрэв, Монгол нийгэм /Нийгэм-философийн анализ/, Улаанбаатар, 2021.
9. С.Түмэндэлгэр, "УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ДЭХ ЖЕНДЭРИЙН АСУУДЛУУД," Социологи, pp. 55-63, 2025.
10. Д. Дашипүрэв., Монголын нийгмийн шинэчлэлтийн үе шатууд, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2022.
11. Д. Дашипүрэв., Монгол нийгэм., Улаанбаатар.: "Сэлэнгэ пресс" ХХК, 2017.
12. Dulam Bumochir, Byambabaatar Ichinkhorloo, Ariell Ahearn, 04 11 2020. [Online]. Available: https://brill.com/view/journals/inas/22/2/article-p183_3.xml.
13. Ганболд Ц., Нансалмаа С., "Ямааны ноолуур бүдүүрэх болсон шалтгаан, хамгаалах арга.," in Цагаан алт ба арьс шир, ноос ноолуурын салбарын тулгамдсан асуудлууд. , 2024.11.08.